

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2023.09.25-2023.12.21/**

2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2023 оны 04 дүгээр улиралд 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 63 албан бичиг ирсэн ба үүнээс хариутай бичиг 17, хариугүй бичиг 46 байгаагаас Захиргааны албанд 48, Үйлдвэрлэл, технологийн албанд 15 албан бичиг хуваарилагдан тус тус хугацаандаа, бүрэн шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр хуваарилагдсан албан бичгүүдийг түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглаж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 96.88%, хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 97.50%-тай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4.32 хоногтой байна.

Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Албан бичиг солилцооны дунпын үйлчилгээний гэрээг цахимаар байгуулсан. Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж, 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хүсэлт гарган Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд хэвийн ашиглаж байна.

Тоон гарын үсгийн хугацаа 2022 оны 09 дүгээр сард дууссан тул дахин хүсэлт гаргаж, хугацааг сунгуулан ашиглаж байна.

Манай байгууллагаас 2023 оны 04 дүгээр улиралд, харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 45 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулан графикаар харуулав.


**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2023 оны 04 дүгээр улирлыг, 2022 оны 04 дүгээр улирлынхтай харьцуулахад,
тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2023 оны 04 дүгээр улирал	63	17	46	4.32	45
2022 оны 04 дүгээр улирал	47	22	25	4.36	63

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

/2023 оны 04 дүгээр улирлыг, 2022 оны 04 дүгээр улирлынхтай харьцуулахад,
графикаар/



Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 4.40 байсан бол энэ онд 4.32 хоног болж 0.08 өдрөөр буурсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил дутагдал, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГАДААД ХАРИЛЦАА БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХДУЛАМ